

МОНГОЛЧУУДЫН НЭГЭН ЗҮЙЛ ШҮТЭЭНИЙ ТУХАЙ¹

А.Ариунболд (Докторант)

МУИС.НШУС

Шашин Судлалын Тэнхим

Түлхүүр үг: Жалханз хутагт, Хотгойд, Хөвсгөл аймаг, Цэнгэл нуур, Зуны гал, Билэгдэмбэрэл гэгээн, Мөрөнгийн төв

Галутга: Бурхны шашин Монголд дэлгэрсэн тэр цагаас олон хутагт хувилгаад тодорсон бөгөөд тэр дундаа Монгол нутгаас Жалханз Хутагтын хувилсан 8 дүр тодорсон байдаг. Энд өгүүлэх IX дэх дүр нутгийн ардын нэрэлдгээр Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/ гэгээний түүхэн амьдрал, үйл ажллагаа нь цаг үеийн байдлаас шалтгаалаад ээдрээтэй агаад онцлог түүхийг туулж ирсэн юм. Түүхийг нутгийн ард түмэн шүтэн дээдэлж байсныг илтгэж Билэгдэмбэрэл гэгээний өмсөж байсан гутлыг өнөө хүртэл гурван үе дамжин хойморын бор авдар дээрээ бурханчлан шүтээгдэж байна.

Энэ нь Монгол улсын түүхэнд "Гутал" шүтэж ирсэн цорын ганц тохиолдол гэдгийг энэ дашрамд онцлон хэлмээр байна.

"Жалханз" гэдэг нь "Ялгуулсан харшийн орой" гэсэн утгатай төвд үг агаад Жалханз хутагтын анхны дүр нь Төвдийн Галдан хийдийн ширээт лам Балжиржамц юм. Харин Ар халхад 1631 онд эхээс мэндэлж, 1634 онд Омбо-Эрдэнийн Лувсанданзан-жанцан нэрээр анх тодорсон байна. Тэр цагаас хойш Жалханз хутагтын хойд дүрүүд Засагт хан аймаг ялангуяа Хотогойд түмэн залан авчирснаар тэр нутагт хэдэнтээ төрөн шашин, амьтны тусын тулд ихийг бүтээж ирсэн түүхтэй. Энд өгүүлэн буй VIII дүрийн Жалханз хутагтаас хойш нутгийн ард олны дунд Жалханз хутагтын IX дүр хэмээн далд шүтэгдсэн Билэгдэмбэрэл та бидэнтэй нэгэн үе хамт амьдарч байсан юм. Дүрүүдийг нэрлэвэл :

- I дүр-Лувсанданзанжамц(1634-1654)
- II дүр-Лувсанданзанбалсан(1656-1740)
- III дүр-Ишгэлэг(1740-1746)
- IV дүр-Галсандамбаяринпил(1746-1794)
- V дүр-Лувсанбалжирлхүндэв(1797-1847)
- VI дүр-Чойнпилжанцан(1848-1854)
- VII дүр-Чойжижалцан(1857-1872)
- VIII дүр -Дамдинбазар (1874-1923) нар юм.

Жалханз хутагтын VIII дүр Дамдинбазар нь Богд хаант Монгол улсын үед төрийг төвшитгөх ажилд төдийгүй Монголын баруун хязгаарыг илбэн тохинуулах хавсарсан сайдаар томилогдож ажиллаж байв. 1923 онд Жалханз хутагт Дамдинбазар таалал төгссөний дараа IX дүрийг тодруулахаар Жалханз хутагтын хүрээ, Тэс Мөрөнгийн хүрээний лам хуврагууд тэр дундаа Тэсийн хүрээ "Дашлин хийдийн" лам нар, Дилав хутагт нарийн нөлөө бүхий хүмүүсээр шинжүүлэн 3-н хөвгүүнийг сонгосон байна.

Улмаар 1925 онд Банчинбогдод айлтгахад IX дүрийг /Солдив/-залбиралд дурьдсан Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/ нэрээр сонгосон байдаг. Ингээд сүсэгтэн олны хүсэлтээр Дашлин хийдийн тэргүүлэгчид 1927 оны 07 сарын 10 нд БНМАУ-ын Бүх Шашны Хэргийг Эрхлэх Газарт хүсэлт гаргаж IX дүрийн Жалханз хутагт Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/-ийг ширээнд залж, баталж өгөхийг уламжилж байсан байна. Гэвч тухайн үеийн орой бусгай 1. Энэхүү өгүүллийг Буурай аав Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын өндөр настан одоо 85 настай Загдын Хүрэл болон нутгийн ард түмний аман дурдатгалд тулгуурлан бичив.

байдал, Коменгерний нөлөөний улмаас ширээнд залагдалгүй хавчин гадуурхагдаж, цагийн эрхээр эгэл хар дүртэйгээр нутгийн ард түмэнд нууцхан шүтэгдсээр 1968 онд элдэв шидийг үзүүлэн бурхны орноо заларсан түүхтэй.

Жалханз хутагтын IX дүр Билэгдэмбэрэл гэгээний намтрыг тодруулбал, Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/ гэгээний өвөг дээдэс нь хуучнаар Засагт хан аймгийн Ахай бэйсийн хошуу/1691-1923/, тэр үеийн Хантайшир уулын аймаг Наранжаргалант уулын хошуу/1924-1931/, одоогын Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл, Түнэл, Их-уул 3-н сумын залгаа Цэнгэл нуурын дэргэдэх Зууны голоор нутаглаж байсан Б.Саруул хэмээх эмэгтэйтэйгээс 1924 он буюу 16-р жарны модон хулгана жилийн хавар Мөнгөн уулын зүүн суга “**Шуугийн халзангийн ам**” хэмээх газар эхийн өргөмөл эцэг Баатарын гэрт мэндэлжээ. Хүүг төрөх үед гэрийн хаяагаар гэрэл цацарч, шар туяа татсан гэж нутгийнхан ярьдаг гэвч хүү тэр үеийн хүүхдүүдийн адил шагай чулуугаар тоглож, хурга тугал эргүүлэн өсөн торниж байв.

Билэгдэмбэрэл хүү гэгээнээр тодорсон нь: Тамгатай 13-н хутагтын нэг Жалханз хутагтыг жанч халсаны дараа сүсэгтэн олны хүсэлтээр Дашлин хийдийн тэргүүлэгчид 1927 оны 07 сарын 10 нд БНМАУ-ын Бүх Шашны Хэргийг Эрхлэх Газарт бичиг илгээсэн байна. **Бичигт:** “...Жалханз хутагтын хойд дүрийг тодруулахдаа хөвгүүдийн дотроос Дэлгэр хан уулын хошууны Ням, Наранжаргалант уулын хошууны Билэгдэмбэрэл / Гэлигдэмбэрэл/, Наранжаргалант уулын хошууны Лувсангийн Чойжил нарын 3-н хөвгүүн мөн гэж сонгосон боловч Чойжил гэгч хүү нас барсан тул лав аль нь гэдгийг Банчин богдоос “Солдэвийн дотор” буулгаж өгөхийг хүсчээ...” Гэтэл Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/ хэмээн буулгасан учир элдэвээр шинжин үзэж Наранжаргалант уулын хошууны Баатарын Саруулын 4-н настай Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/-ийг мөн хэмээн тааварлаж харьяат хийдийн газар сүсгээр суулгаж эрдэм номонд шамдуулахыг ёсоор болгон гүйцэтгэн шийтгэхийг гуйн мэдүүлсүгэй?.

Монгол Улсын 17-р он 07-р сарын 10. Дугаар 9

Тэргүүлэгчид: Ванчинсүрэн,
Жамьяансүрэн, Даравцамчир,
Галсандорж, Дугаржав, Ренчиндорж.

Бага нас: 1928-1929 оны хавьд Дилав хутагт, Дарав бандид нар Цэнгэл нуурын орчим хаваржиж байсан Баатар аажгаанд ирэхэд уурга унасан хүүхэд тоглож байжээ. “Сунтаг шүүж” явсан лам нар гэрт орж мэнд мэдэлцээд Жалханз хутагт Дамдинбазар гэгээний урьд хэргэлэж байсан “Хөөрөг, Аяга, Эрхийг” гарган аяганд нь цай ууж, хөөргөөр нь тамхилхад, өнөө хүүхэн дээд ламаас гэнэт миний гаргүй модон хүнийг яасан бэ? Гэж асуусан гэдэг.

Лам нар урьд дүрийнхээ юмыг нэхэж байна гэж ойлгон Жалханзын хүрээнд буцаж очоод тэр модон хүнийг сургалбал Дамдинбазар гэгээний ах Жамц гэдэг айлд тэр модон хүн нь байсан гэдэг. Мөн энэ хүний тухай Хөвсөл аймгийн Түнэл сумын харьяат өдгөө 98-н настай ахмад дайчин Хашийн сэтэв гуайн “Өвгөн бичээчийн туулсан амьдрал” дурсамж номондоо: Манайхыг Бөөрөлжид байхад Цэнгэлийн Зуун модны газар ганц бие эмэгтэйтэйгээс Жалханзын хойд дүр төрж гэнэ гээд ээж намайг мориндоо сундлаад 10-н хүний хамт Зуун модны газарт очиход хоёр гэр барьсан байв зүүн хойд гэрийн бүслүүрт жижиг гоё улаан эмээлтэй хөх сэрх уяатай байлаа би эмээлтэй ямаа анх удаа харж байгаа тул юун гэгээнтэн мантай тэр ямаанд тохсон эмээлийг их сонирхож билээ. Хүмүүс балчир гэгээнтэн ямаа унаж тоголдог тухай хөөрөлдөж суутал зүүн гэрээс хоёр, гурван настай болуу гэмээр шар торгон дээлтэй хүүхдийг нэг лам тэвэрч гарч ирээд гарт нь судар бариулж хүмүүст адис хүртээж, бас нэг лам рашаан хүртээж цаасанд боосон модны өмхийг утлага болгон өгч байлаа...³ хэмээн бичжээ.

Гэвч Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/ гэгээнийг “Монгол Улсын Засгийн газар 1929 оны 02 сарын 15 нд хутагт хувилгаадын хойд дүрийг тодруулахыг зогсоох тухай” шийдвэр гарсанаар албан ёсоор тодруулах боломжгүй болсон байна. Мөн тухайн үеийн нийгэм улс

2. УТА- Эрдэнэ шанзодвын данс А-72

3. Өвгөн бичээчийн туулсан амьдрал. УБ.,2005. 12 дахь тал

гөрийн байдлаас шалтгаалаад ширээнд нь залж чадаагүйч, нутгийн ард түмэн гэр цагаас өнөөг хүртэл шүтсээр иржээ. Түүнийг багад цаг үеийн байдал, зэвсэгт бослого зэргээс шалтгаалж сүсэгтэн олноос нууж, Шарав лам шашны үйл, ном зааж байсан байна.

Идэр нас: Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/ хүү 10-н наснаас гэнхимд суралцаж Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл, Их-уул, Цагаан-уул сумдад багшилж, аймгийн боловсролын хэлтэст байцаагч мөн цэргийн алба хааж, Орос улсад хоёр ч удаа богино хугацаагаар суралцаж байжээ. Гэвч энэ болгонд хавчлага шахалтан дунд ажиллаж байсан гэдэг. Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/ нь 1940 оод онд Балжинням, 1950 аад онд Цэрэндулам хэмээх хүмүүстэй ханилан сууж байлаа. Гэрээр хүнийг дээр доор гэж алгадаггүй, их тусч, “**их цэвэрхэн хувцасладаг ганган**” дуулж бүжиглэн наргих дуртай нэгэн байжээ.

Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/ гэгээн таалал төгссөн нь: Билэгдэмбэрэл гэгээнийх Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын уугуул Гонгорын / лам / хамар хашаанд гэр нь байжээ. Гэрээр хоёр жил гаран бие нь чилээрхэж, хэвтэрт орж насан эцэстэл нь хамар хашааны Гонгор ламын эхнэр асарсан байдаг. Тэрээр хэлэхдээ би турж эцээд “Мял” богдтой адил болно гэдэг байлаа, Мял богд гэдэг нь гүүний шүтдэг бурхан байжээ. Гэгээнтэн билэгдэмбэрэл нь 1968 оны 02 сарын 23 нд Мөрөнгийн төвд таалал төгсчээ. Түүнийг Мөрөнгийн урд талын элэстэйн ард бунхлан оршуулсан гэдэг.

Бурхан дээрхи гутлын тухайд: Миний ээжийн аав Загдын Хүрэл 1927 оны луу жилийн хавар Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл суманд төрсөн бөгөөд бага эмч, жолооч, агентын ажил насаараа хийсэн нэгэн. Тэрээр 1965 онд Мөрөнгийн төвд Гонгор ламын Билэгдэмбэрэл гэгээнтэй гаарч мэнд усаа мэдэлцэн ярилцаж суутал, харж байснаа дуудан урдаа авчраад, гарын алганд нь идээн дээрхи шар тосноос авч нялаад, “**Өөрийн өмсөж байсан хос хоёр гутлаа тайлан өгч**” за чи энэ гутлыг хадгалж яваарай, чамд итгэлтэй хүн байвал өмсүүлж болно шүү гэж хэлсэн гэдэг. Үүнээс хойш өнөөг хүртэл хоёр хос гутлыг гурван үеийн турш бурханчлан шүтэж байна. Буурай аавын гадны хүн, хүүхдүүд орж ирээд бурхан дээрээ гутал тавьсаныг хараад ихэд гайхан сонирхож, хариад ээж аав, гэр орныхондоо сонин болгон ярьдаг байжээ.

Тэрхүү хос гутал нь яг аль улсад үйлдвэрлэгдсэн гэдэг нь тодорхойгүй авч хийц загвар зэргээс харахад Европын орнуудын аль нэгэнд үйлдвэрлэгдсэн гэдэг нь тодорхой байна. Хийцийн хувьд их чамин, хар өнгийн арисаар үйлдэн ширэн ултай, 37 размераар хийжээ. Одоо байгаа байдлаас харахад Билэгдэмбэрэл гэгээн их цэвэрч нямбаа, дэгжин хүн байсан нь годорхой харагдаж байгаа юм.

НОМ ЗҮЙ

1. Үндэсний Төв Архив - Эрдэнэ шанзодвын данс А-72.
2. Х.Сэгэв, Өвгөн бичээчийн туулсан амьдрал. УБ., 2005.
3. Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын өндөр настан Загдын Хүрэлийн аман дурдатгал.

АННОТАЦИЯ

Со времён распространения буддийской религии в Монголии было признано появление многих особо просвещенных монахов, так называемых хутуктами и хубилганами. Среди них выделяется Жалханз хутукт, который переродился уже восьмой раз в Монголии. Рассматриваемые в данной работе жизнь и религиозная деятельность девятого рода этого хутукта были сложными и особенными в силу того времени. Он был известен в народе как Билэгдэмбэрэл /Гэлигдэмбэрэл/ гэгээн. Земляки боготворили Билэгдэмбэрэла гэгэна и подтверждением тому является тот факт, что его обуви они бережно хранят на алтаре уже в три поколения.

Это является своего рода уникальным случаем в истории Монголии, где обуви стали предметом реликвии.